

**Монгол төрөл хэлнүүд дэх үйлээс нэр бүтээх *-gur² дагаврын тухай
*ШИОТАНИ Шигэки**

The Deverbal Nominal Suffix *-gur² in the Mongolic Languages

SHIOTANI Shigeki

[Summary]

Some of the Mongolic languages have a unique deverbal nominal suffix *-gur² which denotes “ have a habit or a tendency to do something ”.

The author analyzes in detail the origin and the development of the suffix from a diachronic viewpoint, and insists that the dialectal distribution of the suffix coincides with the dialectal classification of the Mongolic languages proposed by Sh. SHIOTANI (2014).

[Түлхүүр үг]

монгол төрөл хэлнүүд; үйлээс нэр бүтээх дагавар; дур сонирхол, дадал заншил

1. Эхлэл

Би энэ өгүүлэлдээ монгол төрөл хэлнүүд дэх «тухайн үйлийг үйлдэх дур сонирхолтой, заншилтай» гэсэн утга санааг илэрхийлэх үйлээс нэр (тэмдэг нэр ч багтана) бүтээх *-gur² дагаврын гарал үүсэл, хувирал хөгжил болон өвөрмөц онцлогийнх нь талаар дурдахын зэрэгцээ энэ дагаврын тархац нь Ш.Шиотанигийн дэвшүүлсэн монгол төрөл хэл аялгуунуудын ангилал (2014)-ыг огтхон ч зөрчөөгүй гэдгийг ч бас дурдаж болмоор байна.

2. Хятад дахь монгол төрөл салангид хэлнүүдийн *-gur² дагаврын байдал

Монгол төрөл хэлнүүдийн дотор Хятадын Ганьсу, Цинхай мужийн салангид хэлнүүдэд хамаарагддаг Баоан, Канжаа, Дуншаан, Монгор зэрэг дөрвөн хэлэнд үйлээс нэр (тэмдэг нэр ч багтана) бүтээх өвөрмөц дагавар байгаа бөгөөд энэ нь зарим үйл үгийн үндсэнд залгагдаж, «тухайн үйлийг үйлдэх дур сонирхолтой, заншилтай» гэсэн утгыг илэрхийлнэ. Харин ч Зүүн ёгор, Дагуур хоёр хэлэнд энэхүү дагавар ер харагдахгүй байна.

Энд Баоан, Канжаа, Дуншаан, Монгор хэлний энэхүү дагавар болон жишээнүүдийг нь үзүүлбэл доорх мэт :

Баоан : -Gөг

Канжаа : -Guar

Дуншаан : -бу

Монгор : -gurtə ~ -gərcdzə

Жишээ нь :

Баоан : ajiGər 《胆小的 “аймхай”》 (< aji- 《害怕 “ай-”》)
la:Gər 《愛哭的 “уйланхай”》 (< la:- 《哭 “уйл-”》)
ceGər 《愛尿炕的 “шээрэн”》 (< ce- 《撒尿 “шээ-”》)
jiχteeGər 《愛打架的 “зодоонч”》
 (< jiχtee- 《打架、互相打 “зодолд-”》)

Канжаа : ajiGuar 《胆小的、怕死鬼 “аймхай”》 (< aji- 《害怕 “ай-”》)
ilaGuar 《愛哭鼻子的人 “уйланхай”》 (< ila- 《哭 “уйл-”》)
᠑iniGuar 《愛笑的 “инээмтгий”》 (< ᠑ine- 《笑 “инээ-”》)

Дуншаан : ajiχu 《胆小鬼 “аймхай”》 (< aji- 《怕 “ай-”》)
uilaχu 《愛哭的 “уйланхай”》 (< uila- 《哭 “уйл-”》)
᠑idzəχu 《怕羞的 “ичимхий”》 (< ᠑idzə- 《羞 “ич-”》)
hət᠑əχu 《没勁的人 “эцэнхий (→ хүчгүй)”》
 (< hət᠑ə- 《乏 “эц- (→ ядар-)”》)

Монгор : la:Gurtə ~ ula:Gərcdzə 《愛哭的 “уйланхай”》
 (< la:- ~ ula:- 《哭“уйл-”》)

Дээр дурдсан Баоан -Gər, Канжаа -Guar, Дуншаан -χu, Монгор -Gurtə ~ -Gərcdzə гэдэг үйлээс нэр бүтээх дөрвөн дагавар нь цөм гарал нэгтэй байгаа бөгөөд харьцуулсан хэл шинжлэлийн аргаар эдгээр хэлбэрээс эртний нийтлэг хэлбэрийг нь ***-gur²** гэж таамаглаж болно.

Монгор хэлний -Gurtə ~ -Gərcdzə дагавар нь ***-gur + či** гэсэн нийлмэл дагавраас бүтсэн нь лавтай бөгөөд нэрээс нэр бүтээх **-či¹⁾** дагавар залгадаг онцлогоороо Монгор хэл нь бусад Баоан, Канжаа, Дуншаан зэрэг гурван хэлнээс ялгаатай юм.

Энэхүү дагаврын гарал үүслийн тухайд бол урьд нь зарим монголч эрдэмтэн²⁾ Баоан, Дуншаан хэлний нийтлэг дагавар гэж үзсэн боловч энэ нь монгол бичгийн хэл болон орчин цагийн монгол хэлний чухам ямар дагавартай гарал нэгтэй болохыг нь өдий хүртэл хэн ч дурдаагүй байгаа.

3. Монгол төв хэл аялгуун дахь ***-gur²** дагаврын байдал

Дундад зууны монгол хэлний байдлыг илэрхийлдэг “Монголын Нууц Товчоо”, “Мукаддимат ал-Адаб” зэрэг сурвалж бичигт энэ дагаврын ул мөр огт харагдахгүй байна. Энэ байдлаас үзэхэд дундад зууны монгол хэлэнд энэхүү дагавар нь огт байхгүй байсан юм уу, аль эсвэл бараг хэрэглэгдээгүй байсан байж тун магадгүй. Харин дээр таамагласан ***-gur²** хэлбэр, илэрхийлэх утга хоёрыг нь харгалзан үзвэл монгол бичгийн хэл (Мо.) болон орчин цагийн монгол хэлэнд үйлээс нэр бүтээх Мо.-уур, -gür (-уур, -үүр) дагавар бий бөгөөд үүнтэй гарал нэгтэй байсан болов уу гэж үзэж байна.

Мо.-уур, -gür (-уур, -үүр)³⁾ дагавар нь монгол бичгийн хэл болон орчин цагийн монгол хэлэнд зарим үйл үгийн үндсэнд залгагдаж, «тухайн үйлийг олон дахин үйлдэх байдалтай» буюу «тухайн үйлийг үйлдэх заншилтай» гэсэн утга санааг илэрхийлэх нэр үг (тэмдэг нэр ч багтана) үүсгэнэ.

Жишээ нь :

Мо. kinaуур (хянуур) «careful, cautious»

(< kina- (хянах) «to check, to examine»)

Мо. doliуанауур (долигонуур) «flattering, sycophantic»

(< doliуана- (долигонох) «to flatter»)

Мо. angуалжауур (ангалзуур) «open-mouthed»

e.g. ангалзуур хүүхэн «a talkative woman»

(< angуалжа- (ангалзах) «to open one’s mouth repeatedly»)

Энэхүү дагавар нь Монгол хэлний Халх, Өвөр монголын аялгуунаас гадна, Халимаг, Буриад хэл зэрэг Монгол төв хэл аялгуунд бүгд харагдаж байгааг дашрамд дурдъя.

4. Хоёр эгшгийн хоорондох ***-g-** гийгүүлэгчийн асуудал

Дээр Хятадын монгол төрөл салангид хэлнүүд дэх ***-gur²** (>-gur) дагаврыг Монгол төв хэл аялгуун дахь ***-gur²** (>-уур) дагавартай гарал нэгтэй байх гэж үзсэнтэй холбогдуулан авиа зүйн талаар нэг юмыг тодруулах хэрэгтэй байна.

Баоан, Канжаа, Дуншаан, Монгор хэлнүүдэд энэ дагаврын хоёр эгшгийн хоорондох ***-g-** нь **-g-** (Баоан, Канжаа, Монгор), **-в-** (Дуншаан) гийгүүлэгчээр хадгалагдсан байхад орчин цагийн монгол хэлэнд энэхүү ***-g-** нь бүрэн гээгдэж, урт эгшиг **-ω-**, **-и-** (-уу-, -үү-) бий болж, авианы талаар яг тохиролцохгүй гэсэн нэг асуудал байна.

Хэдий тийм боловч хоёр эгшгийн хоорондох ***-g-** нь монгол төрөл хэлнүүдийн ихэнх аялгуунд гээгдсэн байхад зарим цөөнх аялгуунд хадгалагдсан

жишээ бага сага тохиолдох нь бий.

*/ -VgV-/ (Mo.-VγV-, -VgV-)
> -G- (~ -B- ~ -X-) / -g- (~ -γ- ~ -x-) > -V:-

Энд “асуух” «to ask» гэдэг үгээр л доор жишээ татъя.

Mo. asaγu- (асуух) «to ask»

а) Дундад зууны монгол хэл :

“Монголын Нууц Товчоо” : asaG-, asaGu- «id.»

“Мукаддимат ал-Адаб” : asaγ-, asaγū- «id.»

б) Монгол төрөл хэлнүүд :

Баоан : asγa- ~ asaγ- «id.»

Зүүн ёгор : — «id.»

Канжаа : asγB- ~ asγш- «id.»

Дагуур : xaso:- «id.»

Дуншаан : asa- «id.»

Монгол : asω:- «id.»

Монгор : sga- «id.»

Энэ байдлаас үзэхэд дээр дурдсан Хятадын монгол төрөл салангид хэлнүүд дэх *-gur² (>-gur) дагавар болон Монгол төв хэл аялгуун дахь *-gur² (>-уур) дагавар нь утгаараа ижил, авианы тохиролцоотой тул гарал нэгтэй дагавар гэж дүгнэж болох бүрэн үндэслэлтэй байна.


5. Монгол төрөл хэлнүүд дэх *-gur² дагаврын ерөнхий байдал ба тархац

Дээр дурдсаныг хураангуйлж, «тухайн үйлийг үйлдэх дур сонирхолтой, заншилтай» гэсэн утга санааг илэрхийлэх үйлээс нэр бүтээх *-gur² дагаврын монгол төрөл хэлнүүд дэх ерөнхий байдлыг нь хүснэгтээр үзүүлбэл доорх мэт :


Эртний монгол хэл	*-gur ²
Монгол бичгийн хэл	-γur, -gür
Дундад зууны монгол хэл	— (?)
Баоан	-Gör
Канжаа	-Guar
Дуншаан	-Bu
Монгор	-Gurteэ ~ -Görçdzэ
Зүүн ёгор Дагуур	—

Монгол	-уур, -үүр
--------	------------

Бас энэхүү дагаврын хувирал хөгжлийн явцыг үг бүтэх ёсны үүднээс задалж, бүдүүвчлэн үзүүлбэл доорх мэт:



Эцэст нь Ш.Шиотанигийн дэвшүүлсэн монгол төрөл хэл аялгуунуудын ангилал (2014) дээр энэхүү дагавар байх эсэхийг тус тус (+), (-) тэмдгээр харуулбал доорх мэт:



Монгол төрөл хэлнүүдийн ангилал ⁵⁾ (Ш.Шиотани 2014)

Дээрх байдлаас үзэхэд энэхүү дагаврын тархац нь тус төрөл хэлнүүдийн ангиллыг огтхон ч зөрчөөгүй, яг тохирч байгааг анхаарна уу.

6. Төгсгөл

Монгол төрөл хэлнүүд дэх «тухайн үйлийг үйлдэх дур сонирхолтой, заншилтай» гэсэн утга санааг илэрхийлэх үйлээс нэр (тэмдэг нэр ч багтана) бүтээх

*-gur² дагаврын гарал үүсэл, хувирал хөгжил болон өвөрмөц онцлогийнх нь талаар дээр дурдсан билээ.

Судалгааны үр дүнд энэхүү дагаврын монгол төрөл хэлнүүд дэх тархац нь Ш.Шиотанигийн дэвшүүлсэн монгол төрөл хэл аялгуунуудын ангилал (2014)-ыг огтхон ч зөрчөөгүй гэдгийг ч бас дурдлаа.

Эцэст нь хэлэхэд, монгол төрөл хэлнүүдэд үг бүтээх дагавруудын гарал үүсэл, хувирал хөгжлийн түүхийг хэлний цуваа цагийн үүднээс нарийвчлан судалж тодруулах нь монгол хэл шинжлэлийн үг зүйн судалгааны салбарт ихээхэн тус нэмрээ үзүүлнэ гэдэгт итгэж байна.

Зүүлт:

- 1) Нэрээс нэр бүтээх -чи дагавар нь монгол бичгийн хэл (Мо.) болон орчин цагийн монгол хэлэнд «тухайн юманд дуртай, чадамгай» гэсэн утга санааг илэрхийлэх дагавартай ижил буй заа.

Жишээ нь :

Мо. ajilči (ажилч) «hard-working, diligent» (< ajil (ажил) «work»)

cf. ajilčin (ажилчин) «worker»

Мо. malči (малч) «skilled in cattle-breeding» (< mal (мал) «livestock, cattle»)

cf. malčin (малчин) «cattle-breeder»

- 2) Өвөр Монголын Их Сургуулийн Монгол хэл бичиг судлах газрын Бөхөө 布和 (1986, 259) -гийн бүтээлээс үзнэ үү.

- 3) Багаж хэрэгслийн нэр үүсгэдэг үйлээс нэр бүтээх Мо.-уур, -gür (-уур, -үүр) дагавар (жишээ нь: Мо. arčiуур (алчуур) «towel» < arči- (арчих) «to wipe» , Мо. tülkigür (түлхүүр) «key» < tülki- (түлхэх) «to push» г.м.) нь дээр дурдсан дагавартай ижил хэлбэртэй боловч илэрхийлэх утга нь адилгүй тул хам цагийн үүднээс хоёр өөр дагавар гэж үзвэл зохино. Харин ч цуваа цагийн үүднээс үзвэл нэг нь «амьтай юм (хүн)» дээр, нөгөө нь «амьгүй юм (юм)» -ан дээр хэрэглэгдэж, үнэндээ «үргэлж тэгдэг юм» гэсэн нийтлэг утга санааг илэрхийлэх тул угтаа гарал нэгтэй ижил дагавар байсан болов уу гэж бодож байна.

- 4) Монгол бичгийн хэл (Мо.)-ний дэвсгэр үсэг буюу үеийн төгсгөлийн гийгүүлэгч -г нь Дуншаан (Дун.) хэлэнд ихэнхдээ гээгдсэн байдгийг анхаарна уу.

Мо.	Дун.		Мо.	Дун.	
<u>yaᠭ</u>	qa	«hand»	<u>geᠷ</u>	giə	«house»
<u>qabaᠷ</u>	qawa	«nose»	<u>urᠲu</u>	fudu	«long»
<u>edür</u>	udu	«day»	<u>quᠷᠳun</u>	ᠭuduᠨ	«fast»

- 5) Тойргийн төвөөс холдох тусмаа монгол хэлтэй холбогдох харьцаа нь улам

Ш.Шиотани

холдохыг харуулсан болно. Монгол төрөл хэлнүүдийг нийтдээ 10 хэлнээс бүрэлддэг гэж үзсэн бөгөөд энд Монгол, Буриад, Халимаг-Ойрд 3 хэлийг “Монгол төв хэл аялгуу”, Баоан, Канжаа, Дуншаан, Монгор, Зүүн ёгор, Дагуур зэрэг 6 хэлийг “Хятад дахь монгол төрөл салангид хэлнүүд” гэж нэрлэн ангилсан болно. Бас миний хийсэн тооцоогоор монгол төрөл хэлнүүдийн яригчийн нийт тоо нь барагцаалбал 7.3 сая болох бөгөөд түүний дотроос Монгол хэл, тухайлбал Халх, Өвөр монголын аялгууны яригчийн нийт тоо нь 5.9 сая гаруй буюу нийт тооных нь бараг 80 хувийг эзэлж байгаа гэсэн үг болно. ШИОТНИ Шигэки (2014), *Монгол хэл ба үлгэрүүд* (『モンゴルのことばとなぜなぜ話』), 211-213, Осака Их Сургуулийн хэвлэлийн компани, Осака.

НОМ ЗҮЙ (Зүйлчилсэн жагсаалт)

Баоан :

陳乃雄 等編 (1986)、『保安語詞彙』、内蒙古人民出版社、呼和浩特.

陳乃雄 編著 (1987)、『保安語和蒙古語』、内蒙古人民出版社、呼和浩特.

Дагуур :

恩和巴圖 等編 (1984)、『達斡爾語詞彙』、内蒙古人民出版社、呼和浩特.

恩和巴圖 編著 (1988)、『達斡爾語和蒙古語』、内蒙古人民出版社、呼和浩特.

Дуншаан :

布和 等編 (1983)、『東鄉語詞彙』、内蒙古人民出版社、呼和浩特.

布和 編著 (1986)、『東鄉語和蒙古語』、内蒙古人民出版社、呼和浩特.

伊布拉黑麥·阿 (1988)、「東鄉語的構詞法」、西北民族学院西北民族研究所編、
『東鄉語論集』、138-156、甘肅民族出版社、蘭州.

Зүүн ёгор :

格日勒圖 (1983)、「試論東部裕固語構詞附加成分」、『西北民族学院学报(哲学社会科学版)』第4期、103-113.

保朝魯 等編 (1985)、『東部裕固語詞彙』、内蒙古人民出版社、呼和浩特.

保朝魯、賈拉森 編著 (1991)、『東部裕固語和蒙古語』、内蒙古人民出版社、
呼和浩特.

Канжаа :

斯欽朝克圖 著 (1999)、『康家語研究』(中国新發現語言研究叢書)、上海遠東出版社、上海.

Монгол бичгийн хэл :

Lessing, F. D. (1960), *Mongolian-English Dictionary*, Berkeley and Los Angeles.

Lubsangjab, Č. (1992), *Mongyol bičig-ün qadamal toli*, Ulaanbaatur.

Монгол хэл :

Шинжлэх Ухааны Академийн хэл зохиолын хүрээлэн (1966), *Орчин цагийн монгол хэл зүй*, Улаанбаатар.

Лувсанвандан, Ш.(1968), *Орчин цагийн монгол хэлний бүтэц, монгол хэлний үг нөхцөл хоёр нь*, Улаанбаатар.

Монголын Нууц Товчоо :

小沢重男 (1984-89), 『元朝秘史全釈 (上・中・下)』、『元朝秘史全釈続攷 (上・中・下)』、風間書房、東京.

Цэрэнсодном, Д. (2000), *Монголын нууц товчоо*, Улаанбаатар.

Монгор :

哈斯巴特爾 等編 (1986), 『土族語詞彙』、內蒙古人民出版社、呼和浩特.

清格爾泰 編著 (1991), 『土族語和蒙古語』、內蒙古人民出版社、呼和浩特.

Мукаддимат ал-Адаб :

Поппе, Н. Н.(1938), *Монгольский словарь Мукаддимат ал-Адаб*, Москва-Ленинград.

Өвөр монгол :

內蒙古大学蒙古学研究院 蒙古語文研究所 編 (1999), 『蒙漢詞典』 (增訂本)、內蒙古大学出版社、呼和浩特.

Халх :

Цэвэл, Я. (1966), *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар.

Bawden, Ch. (1997), *Mongolian-English Dictionary*, KPI, London and New York.

Ganhuyag, Ch. (2002), *Mongolian-English Dictionary*, Ulaanbaatar.

* ШИОТАНИ Шигэки … Япон улсын Осака Их Сургуулийн Хэл соёл судлалын Азийн 1 салбарын профессор